

Түвшинширээ сумын 2021 оны 07 дугаар сарын ажлын товч мэдээ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Улсын Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр албан даалгавар болон аймгийн Засаг даргын захирамжууд, аймгийн Онцгой байдлын газраас өгсөн цаг үеийн холбогдолтой үүрэг даалгавруудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагуудад албан даалгавар болон захирамжуудыг хүргүүлэн, байгууллага бүр төлөвлөгөө гарган ажиллаж байна. 01 дүгээр албан даалгаврын биелэлтийг 7 хоног бүр аймгийн Шуурхай штабт хүргүүлэн ажиллаж байна.

Сумын шуурхай штаб нь 24 цагаар жижүүрлэн ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/71 “Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай” захирамж гарч Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд морины давхил, уралдаан, найр наадам, ойн арга хэмжээ, тэмцээн уралдаан зохион байгуулахыг хатуу хориглож, шаардлагагүй тохиолдолд Коронавирусын өвчлөл ихтэй бүс нутаг руу зорчихгүй байхыг ард иргэдэд уриаллаа. Мөн 15 хүртлэх насны хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэхгүй байхыг аж ахуйн нэгжүүдэд даалгасан байна.

2021 оны 07 дугаар сарын байдлаар сумын нийт хүн ам 3425, сумын нийт өрх 976, хүн ам, өрхийн мэдээллийн цахим санд хяналт тавьж ажиллаж байна. Шинээр төрсөн хүүхэд _ дугаар сарын байдлаар 26, нас барсан 9 хүн бүртгэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 06 дугаар албан даалгаврын хүрээнд 7 хоног бүрийн Даваа гарагт “Хариу арга хэмжээний тайлан”-г “Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт enkhnarand88@gmail.com хаягаар тогтмол явуулж байна.

Багийн Засаг дарга болон байгууллагын дарга эрхлэгч нарт 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах аймгийн Засаг даргын албан даалгавар хүргүүлээд байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нар байгууллагуудын 2022 оны төсвийн төсөл, 2023 – 2025 оны төсвийн төсөөллийг хийж хариуцсан мэргэжилтэнд тушааж программд шивж илгээсэн. Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх 2022 онд ажлуудын санал асуулгыг багийн Засаг дарга нар эрэмбэлэн шивж байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх сумын төвийн нэгдсэн хогийн цэгийг цэгцлэх /төсөвт өртөг 100,0 сая/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг

зарлан тендер нээх, хянан үзэх, үнэлэх ажлыг үнэлгээний хороогоор зохион байгуулж байна. Сумын төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, сумын төвийн камержуулалтын ажлын гэрээг байгуулан ажиллаж байна. 2021 оны аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр худалдан авсан тохижилт үйлчилгээний ковш болон хог зөөврийн машиныг хүлээн авч, ашиглаж эхлээд байна.

Үнэгд багийн нутаг дахь Алтанбулагийн эхийг элсний нүүдэл, малын хөлөөс хамгаалах тор хашлагыг УИХ-ын гишүүн Н.Ганибалын ажлын алба, нутгийн иргэдтэй хамтран гүйцэтгэлээ.

Нийт мал сүргийн 1% хувьд ангилалт хийх аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн дагуу санхүүжилтийг сумын төсөвт суулгуулсан.

2021.06.11-ны өдөр Түвшинширээ сумын Өгөөмөр багийн Таван толгой гэдэг газраас гоц халдварт шүлхий /А0-10/ өвчин батлагдаж, Хорио цээрийн дэглэм тогтоосон байсан ба 2021 оны 07 дугаар сарын 09-ны өдөр уг захирамжийг бууруулж, Хязгаарлалтын дэглэм тогтоох А/73 тоот захирамж гарч голомтын бүсийн айл өрхийн хүн, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавин ажиллалаа. Гоц халдварт шүлхий өвчний гаралт нэмэгдээгүй тул 2021 оны 07 дугаар 23-ны өдөр сумын Засаг даргын А/74 тоот захирамж гарч хязгаарлалтын дэглэм цуцлагдсан.

Голомтын бүсэд Н. Давааням ажиллаж, өдөр бүр хонин сүрэгт үзлэг тандалт хийж, хашаа хороо, худаг уст цэгийг ариутгаж, халдваргүйжүүлж ажиллалаа.

Нийтдээ 10 хашаа 12000 м/кв, 10 ш худаг 2500 м/кв талбай, автомашин 10 ш тус тус ариутгасан байна. Ариутгалд супер килл 5 кг, хай коп 3 кг зарцуулсан байна.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг Сумын Засаг даргын 07 дугаар сарын 06-ны А/72 тоот захирамжийн дагуу эхлүүлсэн. Тарилганд 5 ажлын хэсэг гарч 17 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Тарилгын явц 5 багийн 350 өрхийн үхэр 12500, хонь 160000, ямаа 138000, бүгд 310500 толгой малыг вакцинжуулалтанд хамруулж, хамрагдалт 72,2 хувьтай байна.

Одоогоор сумын хэмжээнд гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийгдэж байгаатай холбогдуулан малын шилжилт хөдөлгөөн, мах, түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэлтийг зогсоогоод байна.

Сумын засаг даргатай хамтран гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажилд хяналт тавьж 3 багийн 10 өрхөөр орж, тарилгын 4 ажлын хэсэгтэй уулзаж тарилгын явц, вакцины хадгалалт тээвэрлэлтэнд өрхийн эрүүл мэндийн дэвтрийн бичилтэнд хяналт тавин ажиллалаа.

Орон нутгийн тарилга болох цусан халдварт, дотрын халдварт хордлого зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт хийсэн тарилгын материалыг хүлээн авч цахим системтэй тулгалт хийж, мал эмнэлгийн газарт хүргүүлэхэд бэлэн болсон байна.

2021 оны 07 дугаар сарын 22-ны өдөр ХХААХҮЯ, Дэлхийн банктай хамтран МАА-н эдийн засгийг нэмэгдүүлэх төсөл /2020-2025/ танхимын сургалтанд Сүхбаатар аймагт 1 өдөр хамрагдаад ирлээ. Уг төсөл нь Баянхонгор, Ховд, Сүхбаатар аймгийн бүх сумдад хэрэгжүүлнэ.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. Амбулаторын нийт үзлэг 320, алсын дуудлага 12, гэрийн дуудлага 9, хэвтэн эмчлүүлэгч 10, Нас баралт 0. Эрүүл мэндийн яамнаас коронавирусын цар тахлын хүрээнд Covid-ийн вакцинжуулалтыг 12 – 17 насны хүүхдийн 2-р тун хэвийн хийгдэж байна.

Тайлан нэгтгэсэн:

Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Ш.Дүүрэнбилэг

Хянасан:

Тамгын газрын дарга

Ц.Ренчинмядаг